



## Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ЧАНАРТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР НӨЛӨӨГ ТООЦОЖ АЖИЛЛАХААР БАЙНА.**



**АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”**



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	3
Хүснэгтийн товьёг .....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3

**БҮЛЭГ 1. ХҮН АМЫГ ЭМЧИЛГЭЭНИЙ ӨНДӨР ИДЭВХТЭЙ, АЮУЛГҮЙ, ЧАНАРЫН БАТАЛГААТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛЭЭР ХАНГАХ, ТҮГЭЭХ ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....**

**А.1 Эмийн сангийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эм хадгалалтад тавигдах шаардлагыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийг хууль журмын дагуу тасралтгүй хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар байна.....**

А.1.1 Монгол улсын эмийн бүртгэлд эмчилгээний өндөр идэвхтэй чанартай, аюулгүй эмийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, өвчлөлийн байдал, бодит судалгаанд үндэслэн бүртгэж байна.....

А.1.2 Эмийн сангийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эм хадгалалтад тавигдах шаардлагыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийг хууль журмын дагуу тасралтгүй хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар байна.....

А.1.3.Төрөөс эмийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлсэн байна.....

А.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлсэн боловч орон нутагт ашиглалт хангалтгүй байна.....

**А.2 Эмийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, шат шатандаа хяналттай ажиллахаар байна.....**

А.2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөн, хяналтыг сайжруулахаар байна.....

А.2.2 Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн зардлыг улсын төсөв болон ЭМД-ын сангаас санхүүжүүлээгүй байна.....

А.2.3 Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлээгүй байна.....

**А.3 Эм зүйн салбарын хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлэхээр байна.....**

А.3.1-А.3.3 Аймгийн ЭМГ-т эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалтын нэгж байгуулагдаагүй байна.....

А.3.4 Эмийн санд мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.....

**БҮЛЭГ 2. ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА.....**

**Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлээгүй байна.....**

Б.1.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлээгүй байна.....

**Б.2 Иргэдийн эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхээр байна.....**

Б.2.1 Эмийн жор бичилт хангалтгүй, эм олголтод тавих хяналт үр дүнгүй байна.....

Б.2.2 Нэгдсэн эмнэлэгт клиник эмзүйн албыг байгуулах, мэргэжлийн клиник эм зүйчдийг ажиллуулах хэрэгцээ бий болж байна.....

Б.2.3 Эмийн сангийн мэргэжлийн хүн хүчнийг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулахаар байна.....

Б.2.4 Иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг сургалт, сурталчилгааны ажлыг зохистой хэмжээнд зохион байгуулжээ.....

Холбогдох байгууллагын санал: .....

Саналд өгсөн тайлбар: .....

ДҮГНЭЛТ:.....

ЗӨВЛӨМЖ: .....

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИЗОУС	Их Засаг Олон Улсын Сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУИС	Монголын Үндэсний Их Сургууль
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШАУИС	Шинэ анагаах ухааны их сургууль
ЭЗШУИС	Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

**ХҮСНЭГТЭН ТОВЬЁГ**

№	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	Эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын улсын төсвөөс олгосон санхүүжилт	10
Хүснэгт 2	ЭМД-ын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт	10
Хүснэгт 3	ЭМД-ийн сангаас хасагдсан санхүүжилт	10
Хүснэгт 4	Мэргэжлийн хяналт шалгалт	17
Хүснэгт 5	Ногдуулсан шийтгэвэр	17

**ЗУРГИЙН ТОВЬЁГ**

№	Зургийн нэр	Хуудас
Зураг 1	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бүтэц зохион байгуулалт	12
Зураг 2	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бүтэц зохион байгуулалт	13
Зураг 3	Эмчийн жор	15
Зураг 4	Иргэдэд зохион байгуулсан сургалт	16
Зураг 5	Эмч мэргэжилтнүүдэд зохион байгуулсан сургалт	16
Зураг 6	Эмийн сангуудтай хамтран зохион байгуулсан сургалт	17

**ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Дүрслэлийн нэр	Хуудас
Дүрслэл 1	Монгол улсын эмийн бүртгэл	5
Дүрслэл 2	Бүртгэгдсэн эм улс, орноор	6
Дүрслэл 3	Нийт үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо. /2016-2020 он/	9

<p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>	<p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийх аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p><b>Аудитын зорилт</b></p>	<p>Аудитыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтлцоо бүрдсэн эсэх</li> <li>➢ Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөл буурч эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх</li> </ul>
<p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>	<p>Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, түгээлт, хяналтын талаарх зохицуулалт, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан тайлан, хяналт-үнэлгээний тайлан, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан шийдвэр, үндэслэл, дээрх жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг баталсан шийдвэр, санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал болон бусад холбогдох баримт материалыг хамрууллаа.</p> <p>Аудитаар аймгийн Аймгийн ЗДТГ-ын хяналт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, өрхийн ЭМТ, сумын ЭМТ, эм ханган нийлүүлэх байгууллага, нийтийн эмийн сангийн холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.</p> <p>.....</p>
<p><b>Аудитын хязгаарлалт аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p>	<p>Аудитыг АДБОУБ (INTOSA)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:20 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүгнэх, дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p>	<p>Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Э.Сүнжидмаа, С.Санчирмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын төлөвлөгөөг 2021 оны 09 дугаар сарын 15-ны өдөр УАГ-аас хүлээн авч, талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2021 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэсэн.</p>
<p><b>Хүндрэл бэрхшээл</b></p>	<p>Аудитын цар хүрээ их, хугацаа богино байснаар ачаалалтай ажиллалаа.</p>

**БҮЛЭГ 1: Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх**

**Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.**

**А.1 Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хангалт, үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үр дүнтэй байгаа эсэх**

**А.1 Эмийн сангийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эм хадгалалтад тавигдах шаардлагыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийг хууль журмын дагуу тасралтгүй хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар байна.**

**А.1.1 Монгол улсын эмийн бүртгэлд эмчилгээний өндөр идэвхтэй чанартай, аюулгүй эмийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, өвчлөлийн байдал, бодит судалгаанд үндэслэн бүртгэж байна.**

УИХ-ын 2014 оны “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай” 57 дугаар тогтоолын 2 дахь заалтын 1 дэх хэсгийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2014 оны 425 дугаар тушаалаар “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталжээ. Төлөвлөгөөнд эмийн чанар, аюулгүй байдлын баталгаанд дараах бодлого чиглэлийг төлөвлөсөн байна. Тухайлбал:

- ✓ Эрүүл мэндийн болон мал эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд нийцүүлэн эмчилгээний өндөр идэвхтэй, чанартай, аюулгүй эмийг Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэх
- ✓ Эмийн чанарыг хянахад эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллага өөрийн харьяаны эсхүл хараат бус, олон улсын ISO 17025 шаардлага хангасан итгэмжлэгдсэн лабораториор эмийн чанарыг баталгаажуулах
- ✓ Эмийн чанарыг хангахад эм үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эмийн сан, эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, чанарын хяналтын лаборатори, эм зүйн болон эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг холбоод оролцуулах
- ✓ Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага нь өөрийн бүтээгдэхүүний чанарын баталгааг хариуцах, бүртгэлийн дараах аюулгүй байдлын тандалт судалгааг хийх үүргийг хүлээх, үр дүнг эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэх тогтолцоог хөгжүүлэх
- ✓ Үндэсний эмийн үйлдвэрийн чанарын баталгааг хангуулж, “Эм үйлдвэрийн зохистой дадал”/GMP/-ын гэрчилгээ олгох

Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмээр хангах зорилгоор эмийн бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсад 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2015 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Эм, эмийн түүхий эдийг бүртгэх журам”-ын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.




2021 оны 09 дүгээр сарын 27-ны байдлаар нийт 4233 эм улсын бүртгэлд бүртгэлтэй байна.

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, УАГ-аас ирсэн судалгаа

Бүртгэгдсэн эм улс, орноор

Дүрслэл-2



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, YAГ-аас ирсэн судалгаа

Эрүүл мэндийн яам “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар ирүүлжээ. /Эх үүсвэр: YAГ-аас/, Үүнд:

- ✓ Үндэсний болон олон улсын ISO 17025 шаардлага хангасан, хөндлөнгийн итгэмжлэгдсэн ХАБҮЛЛ-ийн чанарын хяналтын лабораториор эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах үйл ажиллагаа үндэсний түвшинд тогтмолжсон. Тус лаборатори бүртгэлийн, хяналтын, тандалт судалгааны дээж болон албан байгууллагын хүсэлтээр эмийн шинжилгээг хийж чанарыг нь баталгаажуулж байна.
- ✓ Эрүүл мэндийн яам нь эх орны эмийн бүтээгдэхүүний шинжилгээний аргачлал, фармакопейн өгүүллийг хянах, баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг болсноор эх орны үйлдвэрийн эм улсын эмийн бүртгэлд эрчимтэй бүртгэгдэх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.
- ✓ “Антибиотикийн зах зээлийн дараах чанар аюулгүй байдал”-д мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран тандалтыг хийсэн. Дотоодын үйлдвэрийн тарилгын болон ууж хэрэглэх антибиотикудын идэвхийг МХЕГ-ын олон улсад итгэмжлэгдсэн ХАБҮЛЛ болон ДЭМБ-ын НДЗЭБ-ийн олон улсын итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр фармакопейн шаардлага хангасан.
- ✓ Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага нь өөрийн бүтээгдэхүүний чанарын баталгааг хариуцах, бүртгэлийн дараах аюулгүй байдлын тандалт, судалгаа хийх үүргийг хүлээх, үр дүнг эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэх тогтолцоог Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Эмийн бүртгэлийн журамд тусгагдсан бөгөөд 2015 оноос эхлэн аж ахуйн нэгжээс “Аюулгүй байдлын тайлан”-г авсны эцэст улсын бүртгэлийн хугацааг сунгах үйл ажиллагаа тогтмолжсон.
- ✓ “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/ батламж олгох журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/348 дугаар тушаалаар батлуулсан.

**А.1.2 Эмийн сангийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эм хадгалалтад тавигдах шаардлагыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийг хууль журмын дагуу тасралтгүй хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар байна.**

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд эмийн хүртээмж, хангамжийн талаар дараах бодлого чиглэлийг төлөвлөсөн байна. Тухайлбал:

- ✓ Зайлшгүй шаардлагатай эмийн сонголт, эмнэл зүйн удирдамжийг хүн амын өвчлөлийн байдал, хэрэгцээтэй уялдуулах
- ✓ Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин болон өнчин эм худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, эмийн худалдан авалтын үр ашгийг сайжруулах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх
- ✓ Эмийн түгээлт, хадгалалтын зохистой дадлын шаардлага хангасан эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн зохистой дадлын шаардлага хангасан эмийн сан, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, олгох үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх
- ✓ Эм худалдан авах, хадгалах, түгээх, олгох үйл ажиллагаанд хангамжийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх
- ✓ Эмийн сангийн байршлыг хүн амын нягтрал, суурьшил болон газарзүйн байршилтай уялдуулах

**Эмийн худалдан авалт:**

Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/350 дугаар тушаалын 8 дахь жагсаалт, 2020 оны А/625 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал бүрд тохируулан батлуулан мөрдөж байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4<sup>1</sup>, 8.5<sup>2</sup>-т заасны дагуу тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгохоор байна.

Говь-Алтай аймгийн ЭМГ нь Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг жил бүр нэгдсэн байдлаар зохион байгуулжээ. Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-д 2018 онд 27 багцад 1,243,400.5 мянган төгрөгийн, 2019 онд 29 багцад 1,308,703.9 мянган төгрөгийн, 2020 онд 32 багцад 1,145,638.9 мянган төгрөг, 2021 онд 36 багцад 1,599,298.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга хийжээ. Мөн Ерөнхий гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж, эмийн худалдан авалтын шинэ тогтолцоог бүрдүүлсэн байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг өгөхдөө зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, эмнэл зүйн удирдамж, стандартууд, эмчилгээний үр ашиг, өмнөх онуудын захиалгын байдалд үндэслэжээ. Харин өвчтөний тандалт судалгаан дээр үндэслэсэн эм эмнэлгийн хэрэгслийн бодит хэрэгцээг тооцолгүйгээр тендерийн захиасыг өгдөг нь тайлант хугацаанд нэмж эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах хэрэгцээ шаардлага бий болгодог байна.

Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 35 дугаар тогтоолоор “Эмийн санд тавих нийтлэг шаардлага”-г баталсан бөгөөд энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөхөөр заасан. Эмийн санд тавих нийтлэг шаардлагын 14.2.3-т “Эмийн санд зөвхөн гэрээт эм ханган нийлүүлэх байгууллагаас баталгаажсан захиалгын дагуу, улсын бүртгэлтэй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг татан авна”, 14.2.8-т “Хувь хүн, баталгаагүй эх сурвалжаас эм, эмнэлгийн хэрэгсэл бусад эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг татан авахгүй” гэж заажээ.

Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-д 2018 оноос 2021 онуудад эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа: */Хавсралт-1/*

- ✓ Тендерт шалгараагүй, иргэн ААНБ-с 1,184,836.2 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Үүнээс бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулалгүйгээр 554,532.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан.
- ✓ Үүнээс 767,391.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн сан, хувь хүнээс /жижиглэнгийн үнээр/ худалдан авалт хийжээ.

Эмнэлгүүд нь тендерээр нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг сар бүрээр хувиар гарган татан авалтаа хийдэг ба тасалдуулсан, хугацаа хоцорсон тохиолдолд холбогдох арга хэмжээнүүдийг тухай бүр авч ажилласан байна.

**Эмийн хүртээмж, нөөц бүрдүүлэлт:** Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн хүртээмжийг сайжруулах, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх чиглэлээр НДХ-тэй хамтран цахим жорыг нэвтрүүлэн ажиллаж байна. Эмийн үнийн хөнгөлөлттэй үйлчлэх 33 эмийн сантай гэрээ байгуулан ажиллаж, цахим жорыг нэвтрүүлж зайлшгүй шаардлагатай эмийг 1-2 сараар нөөцлөн ажиллаж байна.

Эмнэлгийн эмийн сан нь зайлшгүй байх нөөцийг бүрдүүлж ажиллаж байгаа нь тодорхойгүй, ялангуяа сумын ЭМТ нь сумын нийтийн эмийн сангаас тасарсан эмийн нөөц бүрдүүлж байгаа нь хууль эрх зүй, стандарттай нийцэхгүй байна.

Аудитаар Нэгдсэн эмнэлгийн 2020, 2021 оны 11,897 өвчтөний түүхийг түүвэрчилж үзэхэд 1,564 иргэн эрүүл мэндийн даатгал бүрэн төлсөн боловч өөрөөсөө хэрэглэсэн 79,611.3 мянган төгрөгийн эмийн үнийг нэхэмжлээгүй байна. Энэ нь нэг талаар иргэд хууль

<sup>1</sup> Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

<sup>2</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

эрх зүйн мэдлэг дутмаг нөгөө талаас эмнэлэг зайлшгүй байх нөөцийг бүрдүүлж ажиллагаагүйтэй холбоотой.

Говь-Алтай аймгийн хэмжээнд нийт 4 ханган нийлүүлэх байгууллага, 33 нийтийн эмийн сан ажиллаж байгаагаас 1-р зэрэглэлийн 1, 2-р зэрэглэлийн 32 эмийн сан байна.

Эмийн сангийн барилга байгууламж, өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмж, эм хадгалалт, эмийн санд тавигдах эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт: /Хавсралт-2а,б,в,г/

**Эм ханган нийлүүлэх байгууллагын хувьд:**

- ✓ Байр нь ачаа буулгах, тээвэрлэхэд хүрэлцэхүйц гадна талбайгүй.
- ✓ Ази фарм ХХК, Мөнхийн тун ХХК хадгалалтын горимд нийцсэн агуулахгүй.
- ✓ Мөнхийн тун ХХК нь эмийн сангийн агаарыг цэвэршүүлэх зорилгоор суурин буюу зөөврийн нян устгах гэрлийг ажиллуулаагүй.

**Нийтийн эмийн сангийн хувьд:**

- ✓ Бугат, Дэлгэр, Төгрөг, Цээл, Чандмань, Шарга, Халиун сумын хувийн эмийн сан нь сумын ЭМТ-ийн байранд байрлаж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Чандмань сумаас бусад нь түрээсийн төлбөр төлдөггүй байна.
- ✓ Дарив, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Цээл, Чандмань, Эрдэнэ сум, Баянтоорой тосгоны нийтийн эмийн сангийн үйлчлүүлэгчдэд зориулсан хаалга нь бараа хүлээн авах хаалганаас ангид байхгүй.
- ✓ Цалгих буянт ХХК Тунамал эмийн сан, Бугат, Төгрөг, Цээл, Чандмань Шарга, Эрдэнэ сум, Гуулин тосгоны нийтийн эмийн сан нь эм, эмнэлгийн хэрэгсэл, туслах материал, түүхий эдийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах нөхцөл бүрдүүлсэн нөөцийн өрөөгүй.
- ✓ Ихэнх нийтийн эмийн санд ажилчдын амралтын өрөө, эрхлэгчийн өрөө, ариун цэврийн өрөө байхгүй.
- ✓ Бугат, Жаргалан, Чандмань сумын нийтийн эмийн сан нь эм хадгалах хөргөгч, хөргүүргүй.
- ✓ Шарга сумын нийтийн эмийн санд бар кодын машин эвдэрсэн, Баянтоорой тосгоны эмийн сан нь сүлжээ байхгүйн улмаас бар кодын машин ашигладаггүй байна.
- ✓ Бугат, Дэлгэр, Жаргалан сумын нийтийн эмийн санд нян устгах гэрэл байхгүй
- ✓ Амндэм-Алтай ХХК, Хишиг Арвин дэлгэрэх, Түмэн туяа ХХК, Ариунтан Алтай ХХК, Номгон гэгээн фарм ХХК нь нөөцийн өрөөнд термометр, чийг хэмжигчийг эгзэгтэй цэгт байрлуулаагүй, заалтыг өдөр тутам хянаж, тэмдэглэл хөтлөөгүй.

**Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн хувьд:**

- ✓ Эмийн нөөцийн өрөө хүрэлцээ муутай. Диализын эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалалтын горим зөрчиж ус нэрэх өрөөнд байрлуулсан.
- ✓ Нөөцийн өрөө нь эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах шаардлагыг хангасан хүрэлцэхүйц хэмжээний зориулалтын тавиур, лангуу байхгүй.
- ✓ Нөөцийн өрөөнд термометр, чийг хэмжигчийг эгзэгтэй цэгт байрлуулж, заалтыг өдөр тутам хянаж, тэмдэглэл бүрэн хөтлөөгүй.
- ✓ Агаар ариутгах дэлгэц бүхий нян устгах гэрлийг шалнаас дээш 2 метрийн зайд тусгай сууринд бэхлэж суурилуулаагүй. Нян устгах гэрлийг ажиллуулсан бүртгэл хөтлөөгүй.

**Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн хувьд:**

- ✓ Дарив, Тайшир, Тонхил, Цогт, Шарга, Цээл сумын ЭМТ-ийн эмийн сангийн өрөө нь зориулалтын бус.
- ✓ Эмийн сангийн өрөө тасалгаа шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал эмийн нөөцийн өрөө, ажилчдын амралтын өрөө, ариун цэврийн өрөө, эрхлэгчийн өрөөгүй байна.
- ✓ Эмийн сангийн тавилга, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн шаардлагын хувьд эм хадгалах хөргөгч, компьютер, нян устгах гэрэл, термометр, чийг хэмжигч, зориулалтын тавиургүй.
- ✓ Хэрэглэх хугацаа дууссан эмийг тусгаарлаагүй.
- ✓ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн орлого, зарлагын бүртгэлийг бүрэн бүртгээгүй.
- ✓ Эмнэлгийн эмийн санч эмийн нэр төрлийн тайлан, үлдэгдлийн мэдээг гаргаагүй, ариутгасан эмийн бүртгэл байхгүй, тасарсан эмийн бүртгэл, зохистой эмийн мэдээлэл сурталчилгаа явуулсан бүртгэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны бүртгэл байхгүй байна.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын шаардлага:**

Аудитаар 11 байгууллагын эмийн санд хяналт хийхэд 6,631.3 мянган төгрөгийн үнэтэй 129 нэр төрлийн 6,737 ширхэг эмийн хугацаа дууссан, 977 мянган төгрөгийн үнэтэй 19 нэр төрлийн 6,312 ширхэг эмийн хугацаа дуусах дөхсөн, 622.0 мянган төгрөгийн үнэтэй 30 нэр төрлийн 283 ширхэг эм, тарианы хадгалалтын горим алдагдан эмчилгээнд хэрэглэх боломжгүй болсон байна. /Хавсралт-3/

Эмийн сангийн стандартад 5000 хүн ам тутамд, 500 метр зайтай байна гэсэн заалтыг эмийн сангуудын өрсөлдөөнийг дэмжих, цаашид эмийн үнийг бууруулах зорилгоор энэхүү хязгаарлалтыг хассан байна.

**А.1.3 Төрөөс эмийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлсэн байна.**

Төрөөс Монгол Улсын хэмжээнд 2020 онд үйлдвэрлэлийн чиглэлээр 38, ханган нийлүүлэх чиглэлээр 384 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо. /2016-2020 он/  
Дүрслэл-3



Улсын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 38 үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг. Зарим байгууллагууд нь эм үйлдвэрлэх, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн тусгай зөвшөөрлийг давхар авсан байдаг.

Эх сурвалж: Эм зүйн салбарын үзүүлэлт, УАГ-аас ирсэн судалгаа


2020 онд эмийн үйлдвэрийн тусгай зөвшөөрөлтэй 24 үйлдвэр дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Нийт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэл  
2020 он  
Дүрслэл-4



Эх сурвалж: Эм зүйн салбарын үзүүлэлт, УАГ-аас ирсэн судалгаа

Эмийн үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл  
2020 он  
Дүрслэл-5



2020 онд Монгол улсын хэмжээнд 38 эмийн үйлдвэр ажиллаж нийт 63.3 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 61.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Үүнээс 39.3 тэрбум төгрөгийн европ эм үйлдвэрлэж, 39.1 тэрбум төгрөгийн борлуулалт, 22.9 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, 22.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 1.2 тэрбум төгрөгийн биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 1.8 тэрбум төгрөгийн уламжлалт эм үйлдвэрлэж, 1.4 тэрбум төгрөгийн борлуулалт, 7.1 тэрбум төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 6.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ.

2020 онд үйлдвэрлэсэн үндэсний үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг нэр төрлөөр авч үзвэл нийт 273 нэр төрлийн эм үйлдвэрлэснээс 120 (44%) нэрийн эм, 15 (5.1%) нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 18 (6.6%) нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн, 100 (37%) нэрийн уламжлалт эм, 20 (7.3%) нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Эм зүйн салбарын үзүүлэлт, УАГ-аас ирсэн судалгаа

**А.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлсэн боловч орон нутагт ашиглалт хангалтгүй байна.**

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын [www.licemed.mohs.mn](http://www.licemed.mohs.mn) цахим хуудсанд эмийн бүртгэл, экспорт, импортын лиценз, бүртгэгдсэн эм, оношлуур, БИБ, түүхий эдийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл, гаж нөлөөг байршуулсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлсэн боловч эрүүл мэндийн байгууллагуудын ашиглалт хангалтгүй, хүн амын эмчилгээнд хэрэглэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэсэн эсэхийг хянадаггүй байна.

**А.2 Эмийн сангийн санхүүжилт үр ашигтай байгаа эсэх**

**А.2 Эмийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, шат шатандаа хяналттай ажиллахаар байна.**

**А.2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөн, хяналтыг сайжруулахаар байна.**

Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын улсын төсвөөс олгосон санхүүжилт

Хүснэгт-1

/мянган төгрөг/

эх үүсвэр	2018 он		2019 он		2020 он	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
үндсэн санхүүжилт	1,367,458.3	1,351,319.5	1,724,673.4	1,688,848.9	1,645,311.4	1,576,360.3
нэмэлт санхүүжилт	-	5,942.9	-	6,331.6	-	77,366.1
үүнээс төр дах эмийн зардал- Нэгдсэн эмнэлэг	16,336.8	16,336.8	24,797.9	24,797.9	30,799.4	30,799.4

Эх сурвалж: Сангийн яамны цахим сайт, Говь-Алтай аймгийн ЭМГ-аас

ЭМД-ын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт

Хүснэгт-2

/мянган.төгрөг/

ДД	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	2018 он		2019 он		2020 он	
		төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл
1	Улсын эмнэлгийн дүн	2,338,832.6	2,338,310.7	2,513,518.1	2,513,518.1	3,185,677.2	3,123,284.0
2	В,С вирусны илрүүлэг баталгаажуулалтын дүн	64,657.2	28,404.5	31,462.5	31,462.5	16,750.0	6,979.0
3	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн дүн	120,088.5	11,009.0	26,954.0	23,960.0	73,202.8	90,187.0
4	Хувийн эмнэлгийн дүн	209,295.2	181,345.0	163,982.8	163,982.8	421,419.1	274,289.7
5	Шүдний эмнэлгийн нийт дүн			115,980.0	115,980.0	97,800.0	89,640.0
6	Сувиллын нийт дүн	108,900.0	108,900.0	168,740.0	168,740.0	467,500.0	458,890.0
7	Эмийн сангийн дүн	380,000.0	273,629.4	419,127.0	431,010.9	439,986.1	498,363.0
8	Өрх сум тосгоны ЭМТ-ийн нийт дүн	292,148.2	53,378.0	168,459.7	168,459.7	382,055.3	241,567.3
9	Элэгний В,С вирусны эмийн үнийн дүн	339,153.5	203,115.0	66,161.1	66,161.1	96,397.5	52,027.1
<b>ДҮН</b>		<b>3,853,075.2</b>	<b>3,198,091.5</b>	<b>3,674,385.1</b>	<b>3,683,275.0</b>	<b>5,180,788.0</b>	<b>4,835,227.1</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн ЭМД-ийн сан

Дээрх судалгаанаас үзэхэд ЭМД-ийн сангаас авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт жил ирэх тусам нэмэгдсэн байна. Тухайлбал:

✓ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12-р сарын 27-ны өдрийн 24-р тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн баталж, 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Жагсаалтад насанд хүрэгчдийн 170 ерөнхий нэршлийн 638 эмийг 20-80% хүртэл, хүүхдийн 59 ерөнхий нэршлийн 174 нийт 812 худалдааны нэрийн эмд дунджаар 50%-80% үнийн хөнгөлөлтийг үзүүлж байна. ЭМД-ийн сангаас 2018 онд 273,629.4 мянган төгрөг, 2019 онд 431,010.9 мянган төгрөг, 2020 онд 498,363.0 мянган төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийг олгожээ.

ЭМД-ийн сангаас хасагдсан санхүүжилт

Хүснэгт-3

/мянган.төгрөг/

ДД	Байгууллагын нэр	2018	2019	2020
1	Улсын эмнэлгийн дүн	849.4	27,285.5	320,485.2
2	Өрх сум тосгоны ЭМТ-ийн нийт дүн	-	-	21,159.4
<b>ДҮН</b>		<b>849.4</b>	<b>27,285.5</b>	<b>341,644.6</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн ЭМД-ийн сан

Дээрх судалгаанаас үзэхэд эрүүл мэндийн байгууллагууд нь ЭМД-ийн сангийн цахим системд өвчтөний мэдээллийг зөрүүтэй шивсэн, өвчтөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй, эмнэлэгт хэвтэх хугацаандаа оношилгоо, амбулаторийн үзлэгт хамрагдсан зэрэг шалтгаанаар 2018 оноос 2020 онуудад нийт 369,779.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авах боломжийг алдсан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 22.1-т "Эрүүл мэндийн байгууллага сайн дурын үндсэн дээр өөрийн байгууллагын үйл ажиллагааг болон хүн амд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний технологи, чанарыг үнэлүүлж, магадлан итгэмжлэл авна.", Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын хавсралт "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын 5.2-т "Давтан магадлан итгэмжлэлд орох эрүүл мэндийн байгууллага нь батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө хүсэлтээ гаргасан байна", Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах үндсэн гэрээний 4.14.1-т "Тухайн эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа нь дуусгавар болсон, магадлан итгэмжлэл хоорондын хүчинтэй хугацаа нь тасарч сунгагдсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний зардлыг олгохгүй" гэж заасан.

Аудитын хугацаанд Бугат, Дарив, Тайшир, Чандмань сум, Баянтоорой тосгоны ЭМТ-ийн магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан байгаа нь ЭМД-ийн сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт авах боломжийг мөн адил алдаж байна. Эдгээр байгууллагууд магадлан итгэмжлэлийн хугацаа сунгах хүсэлтээ аймгийн ЭМГ-т хүргүүлжээ.

Аудитаар Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, "Жаргалан-Алтай", "Марал-Алтай", "Энх-Алтай" өрхийн ЭМТ, Тайшир, Дэлгэр, Төгрөг, Шарга, Бугат сум, Гуулин тосгоны 2020 оноос 2021 оны өвчтөний түүхийг түүвэрчилж үзэхэд:

**ЭМД-ийн сангийн санхүүжилтийн хувьд:**

- ✓ Нэгдсэн эмнэлэг нь 36 өвчтөний, Уламжлалт анагаах ухааны төв нь 67 өвчтөний мэдээллийг ЭМД-ийн сангийн цахим сайтад огт шивээгүйгээс 27,846.6 мянган төгрөгийг санхүүжилт авах боломжийг алдсан байна.
- ✓ ЭМД-ын сангаас 2020 онд олгосон эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тулган үзэхэд Шарга сумд 5, Тайшир сумд 7 өвчтөний түүхийн баримт бүрдэл дутуу байхад 516.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.
- ✓ Нэгдсэн эмнэлэг нь ЭМД-ын сангаас өвчтөний оношийг зөрүүтэй нэхэмжилсний улмаас 1,839.9 мянган төгрөгөөр санхүүжилтийг илүү, дутуу авсан.

**Эмийн санхүүжилтийн үр ашгийн хувьд:**

- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1.5<sup>3</sup>-д заасны дагуу эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх хугацаандаа өөрөөсөө төлсөн эмийн үнийг, тусламж үйлчилгээ үзүүлсэн байгууллагаас нэхэмжлэх эрхтэй гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгт ирүүлсэн 2020-2021 оны өргөдлийг давтан тулгаж үзэхэд нийт 67 иргэнээс 34,082.4 мянган төгрөгийн эмийн үнийг нэхэмжилснээс 50 иргэнд 18,716.9 мянган төгрөгийг нөхөн олгосон. Харин 7,923.3 мянган төгрөгийн эмийн үнийг олгоогүй нь хэвтэн эмчлүүлсэн хугацаанаас өөр хугацаанд худалдаж авсан эмийг нэхэмжилсэн, мөн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад байхгүй эм, өвчний түүхэнд бичигдээгүй эмийг нэхэмжилдгээс чанарын албанаас хяналт, шалгалт хийж хассан байна.
- ✓ Нэгдсэн эмнэлэг 17 иргэний эмчилгээний явцад өөрөөсөө хэрэглэн нэхэмжилсэн 7,442.0 мянган төгрөгийн эмийн үнийг буцааж олгоогүй нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1.8<sup>4</sup> гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ✓ Нэгдсэн эмнэлгийн 1 өвчтөний эмчилгээний картад өөрөөсөө авсан эмийн бүртгэлгүй байхад 220.0 мянган төгрөгийн эмийн үнийг буцаан олгосон.
- ✓ Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслээс 10 нэр төрлийн эмийн зарцуулалтыг өвчтөний түүхийн хэрэглэсэн эмийн жагсаалттай тулгахад 3,285.0 мянган төгрөгийн үнэ бүхий 93 ширхэг эмийн зөрүү гарлаа.
- ✓ Ковидын төлбөртэй оношлуурын үнэ болох 207.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй.
- ✓ Нэгдсэн эмнэлэг нь 2019, 2020, 2021 онд 2 өвчтөнд 4,000 ширхэг 50,000.0 мянган төгрөгийн хэвлийн диализын уусмалыг, 3,973 ширхэг 2,979.7 мянган төгрөгийн хэвлийн диализын уусмалын бөглөөг анхан шатны баримтгүй, эмчийн зөвшөөрлийн бичиггүйгээр гэрээр олгожээ.
- ✓ Нэгдсэн эмнэлэг, "Жаргалан-Алтай", "Марал-Алтай", "Энх-Алтай" өрхийн ЭМТ, Дэлгэр, Шарга, Төгрөг, Бугат сум, Гуулин тосгоны ЭМТ-ийн 125 өвчтөний түүхэнд шинжилгээний бичиг байхгүй,

<sup>3</sup> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах

<sup>4</sup> Даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох

Нэгдсэн эмнэлэгт 4 өвчтөний түүхэнд хэвтэх зөвшөөрлийн бичиг байхгүй байхад эмчилгээг хийсэн байна.

Мөн зарим эрүүл мэндийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэлд биет тооллого хийхэд:*Хавсралт-4,5/*

- ✓ Эмийн биет тооллого хийхэд байвал зохих үлдэгдлээс 36,720.5 мянган төгрөгийн 43,149 ширхэг эм илүүдэж, 32,791.2 мянган төгрөгийн 38,745 ширхэг эм дутагдлаа. Энэ нь нэг талаас эмийн санч эмийн нэр төрлийн тайлан гаргадаггүй, нягтлан бодох бүртгэлд байгаа эмийн үлдэгдэл эмийн санд байгаа үлдэгдлээс нэр, төрөл, тоо хэмжээ, үнийн хувьд зөрүүтэй, нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлээр хяналт тавьж алдааг засварладаггүйтэй холбоотой.
- ✓ Нэгдсэн эмнэлгийн диализын тасагт хэрэглэсэн эмийн орлого зарлагын тайлан зөрүүтэй, анхан шатны баримтаар нотлогдохгүй, эмийн сангийн байвал зохих үлдэгдлээс 8,307.5 мянган төгрөгийн үнэтэй 841 ширхэг эмийн зөрүүтэй байна. Тус тасагт байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл нь эмнэлгийн эмийн санд байршуулаагүй, бүртгэл тооцооны хяналтгүй зарцуулагдаж байна.
- ✓ Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн нөөцөд зайлшгүй байх эм, тарианд тооллого хийхэд байвал зохих үлдэгдлээс 136 нэр төрлийн 374 ширхэг эм тариа дутагдаж, 112 нэр төрлийн 347 ширхэг эм тариа илүүдсэн.

**А.2.2 Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн зардлыг улсын төсөв болон ЭМД-ын сангаас санхүүжүүлээгүй байна.**

ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2018 оны 17 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт “Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хяналт тавих журам”-г баталсан.

Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн зардлыг улсын төсөв болон ЭМД-ын сангаас санхүүжүүлээгүй байна. Нэгдсэн эмнэлэгт 2019, 2020 онд 12 иргэнд түнх, өвдөг солих мэс засал хийгдсэн боловч шаардагдах төсөв байхгүйн улмаас өвчтөн ойролцоогоор 22,100.0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн зардлыг өөрөөсөө гаргажээ.

Цаашид Нэгдсэн эмнэлэгт өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл шаардлагатай мэс засал хийгдэхээр байгаа тул эрүүл мэндийн байгууллагаас олгогдох төсвийг баталж өгөх нь зүйтэй байна.

**А.2.3 Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлээгүй байна.**

Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлээгүй байна.

- **А.3 Эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангах тогтолцоог бүрдүүлж, эм зүйн салбарын хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлсэн эсэх**

**А.3 Эм зүйн салбарын хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлэхээр байна.**

**А.3.1-А.3.3 Аймгийн ЭМГ-т эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалтын нэгж байгуулагдаагүй байна.**


Аливаа улс орны төрөөс хэрэгжүүлж буй эрүүл мэндийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээний зохицуулалт мөн.

ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоолоор ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагджээ. Тус байгууллагын хувьд оношилгооны өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлснээр хүн амыг шаардлагатай эмээр тасралтгүй, жигд хүртээмжтэй хангаж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, түүнчлэн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохицуулалтын үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх зорилтуудыг тавин ажиллаж байна.

Эм зүйн салбарыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлж, бүтэц, системийг боловсронгуй болгосноор Эрүүл мэндийн, Эмнэлгийн тусламж үйлчилгээний, Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, зайлшгүй шаардлагатай эм, өнчин эм, төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн тасралтгүй хангамжийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх замаар хүн амын хэрэгцээг хангаж, эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах нөхцөл бүрдэж байгаа юм.

Мөн олон улс дахь сайн туршлагыг судалж, оношилгоо, шинжилгээ, чанарын баталгаажилтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэн, ДЭМБ болон гадны бусад байгууллагуудын зөвлөмж, стандартын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлснээр дуураймал, стандартын бус эмийн тархалтыг таслан зогсоох боломж бүрдэх юм.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бүтэц зохион байгуулалт *Зураг-2*



Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бүтэц зохион байгуулалтыг үзэхэд аймгийн ЭМГ-т эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалтын нэгж байгуулагдаагүй байна.

**А.3.4 Эмийн санд мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.**

Монгол улсад эм зүйч бэлтгэж байгаа АШУУИС, ЭЗШУИС, ЭТҮГЭН, ШАУИС, МУИС, Оточ-манрамба, ИЗОУС сургуулиуд байгаа бөгөөд жилд дунджаар 340-360 эмзүйчийг төгсгөдөг байна. АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар сургууль нь 2018 оноос 2021 онуудад нийт 126 эм найруулагч төгсгөсөн ба үүнээс 111 нь мэргэжлийн дагуу ажил эрхэлж байна.

Он	Төгсөгч	Ажил эрхлэлт
2018	23	23
2019	21	18
2020	25	22
2021	57	48
<b>Нийт дүн</b>	<b>126</b>	<b>111</b>

Эх сурвалж: АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар сургуулиас

Говь-Алтай аймгийн хэмжээнд нийт 4 ханган нийлүүлэх байгууллага, 33 нийтийн эмийн санд 105 ажилтан ажиллаж байна. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлагын 5.2-т “Нийтийн үйлчилгээний эмийн сангийн үйл ажиллагааг мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан эм зүйч гардан удирдаж, эрхлэгчийн үүрэг гүйцэтгэнэ”, 5.4-т “Сумын эмийн сангийн эрхлэгчийн үүргийг эм зүйч эсхүл эм найруулагч гүйцэтгэнэ” 5.5-т “Эмнэлгийн эмийн санг эм зүйн албаны менежментээр эсвэл клиникийн эм зүйн чиглэлээр мэргэшсэн эм зүйч удирдаж, эрхлэгчийн үүргийг гүйцэтгэхээр байна.

Аймаг, сумдын эмийн сангийн хүний нөөцөд судалгаа хийж үзэхэд: /Хавсралт-6,7,8,9/

✓ Дарив, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ сум, Баянтоорой тосгоны ЭМТ-ийн эмийн сангийн эрхлэгчийн үүргийг эм найруулагч мэргэжилгүй ажилтан гүйцэтгэж байна.

- ✓ Дэлгэр, Төгрөг сум, Гуулин тосгоны ЭМТ-ийн эм найруулагч нь үндсэн ажиллаж буй эмийн сангаас гадна сумын хувийн эмийн сангийн эрхлэгчээр давхар ажиллаж байна. Мөн Баян-Уул сумын эмийн санч нь Баян гурван жаргалант БГБХН-ийн Мөнгөн дээд эмийн сангийн эрхлэгчтэй харилцан хамаарал бүхий байгаа нь Эмийн санд тавих нийтлэг шаардлагын 6.3-т<sup>5</sup>, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1<sup>6</sup>-д заасныг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна.
- ✓ Ази фарм ХХК, Эм хангамж ХХК, Хишиг Арвин дэлгэрэх ХХК, Сант арвин ХХК Ээлт эмийн сан, Номгон эгээн фарм ХХК-ийн эмийн сангийн эрхлэгч нь мэргэжлээрээ 3-аас доош жил ажилласан байхад эмийн сангийн үйл ажиллагааг гардан удирдаж, эрхлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.
- ✓ Нэгдсэн эмнэлэг нь 231 ортой бөгөөд үүнд 5-6 клиник эмзүйч ажиллахаар байна. Гэвч мэргэжлийн клиник эмзүйч байхгүй, 1 эм судлаач ажиллуулж байна.
- ✓ Нэгдсэн эмнэлэг нь эм зүйн алба байгуулаагүй, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

## БҮЛЭГ 2: Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөл буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлээгүй байна.

### Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн эсэх эсэх

Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлээгүй байна.

#### Б.1.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлээгүй байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн баримт материал аймгийн ЭМГ-т байсангүй. Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай” 35 дугаар тогтоол батлагдсан. Дэд хөтөлбөрт эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалтыг шийдвэрлэн, тусгай зөвшөөрөлтэй болгож, иргэдэд чанартай үйлчилгээг хүргэх гэсэн зорилт тавьж ажиллажээ.

Эмийн эргэлтийн сан нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлгүй, томилогдсон удирдлагагүй, стандартын шаардлагад нийцсэн байргүй, байгууллагын статус тодорхойгүйгээр үйл ажиллагаа явуулж байсныг 2018 онд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас “хууль тогтоомжийн дагуу эмийн эргэлтийн сангийн статусыг тодорхой болгож, үйл ажиллагааг хуульд нийцүүлэх” талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх албан шаардлагыг аймгийн ЭМГ-ийн удирдлагад хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 62 дугаар тогтоолоор сумын эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарган, аймгийн Засаг даргын 2019 оны А/605 тоот захирамжаар эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллагын нэрийг баталжээ.

### Б.2 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн эсэх

Б.2 Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхээр байна.

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эмийн зохистой хэрэглээнд дараах бодлого чиглэлийг төлөвлөсөн байна. Тухайлбал:

- ✓ Эмнэл зүйн удирдамжийг нотолгоо, судалгаа, орчин үеийн эмчилгээний технологи, эмнэлгийн тусламжийн тухайн шатлалд нийцүүлэн мэргэжлийн холбооны саналыг харгалзан шинэчлэх, боловсруулж мөрдүүлэх
- ✓ Эмнэл зүйн удирдамжийг баримтлан эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд нийцүүлэн жор бичих дадлыг төлөвшүүлэх

<sup>5</sup> Эм зүйч, эм найруулагч нь үндсэн ажиллаж буй эмийн сангаас гадна өөр эм хангамжийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа хавсран гүйцэтгэхгүй ба тухайн ажиллаж байгаа аж ахуйн нэгж нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

<sup>6</sup> Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

- ✓ Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан үе шаттайгаар хөгжүүлэх
- ✓ Эмнэлэг бүрд эм зүйч, эм зүйн албыг байгуулж, хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлсэн тусламж үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх
- ✓ Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт Төрөөс эмийн талаарх баримтлах бодлого, зайлшгүй шаардлагатай эм, эмнэл зүйн удирдамж, эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх, хэрэглэгчдэд өгөх зөвлөмжийн асуудлыг тусгах
- ✓ Эмийн зохистой хэрэглээний талаар хэрэглэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх
- ✓ Эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагын үнэлж, зөвшөөрсөн мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэн, хэрэглэгчид түгээх тогтолцоог бүрдүүлэх
- ✓ Эмийн лавлахыг эмнэл зүйн удирдамжид үндэслэн боловсруулж, эмнэлгийн мэргэжилтэнд түгээх
- ✓ Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд тавих ёс зүйн шалгуур”-т нийцүүлэн хэрэгжүүлэх
- ✓ Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор эмд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх


**Б.2.1 Эмийн жор бичилт хангалтгүй, эм олголтод тавих хяналт үр дүнгүй байна.**

Эмнэлгийн нийт жор бичих эрх бүхий эмч нарын дунд MNS 5376:2014 жор бичилтийн стандартын хэрэгжилтийн судалгаа хийхэд 31,8% нь үйлчлүүлэгчийн картад 55,5% нь MNS 5376:2014 стандартын жорын маягтад 13,7% нь бусад гэсэн судалгаа хийгджээ. Эмийн жор бичилтийн стандартын дагуу MNS 5376:2014 жор бичилтийн стандартын хуудсан дээр эмийг бичиж хэвшүүлэх тал дээр илүү их анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Аудитаар нийтийн эмийн санд эмчийн бичсэн жорд хяналт тавихад эмчийн тамга тэмдэггүй, өвчтөний нэр, онош байхгүй, стандартын дагуу бүрэн бичээгүй, эмийн тун хэмжээ тодорхойгүй зэрэг хүчингүй жорыг бичиж байна.

Зураг-3

Эмчийн жор



Эх сурвалж: Нийтийн эмийн сангаас

Иргэд эмийн зохистой хэрэглээ, антибиотикийн талаар мэдлэг муугаас шалтгаалан нийтийн эмийн сангаас дур мэдэн жоргүй эм авдаг зөрчил байсаар байна. Мөн үйлчлүүлэгчийн картад эмч жор бичиж өгснөөр эмийн санд жорын маягтыг хадгалах, жорын бүртгэл хөтлөх боломжгүй болдог хүндрэл бэрхшээл байна.

Иймд эмч жорыг бичихдээ цахим хэлбэрээр бичвэл дээрх зөрчлийг арилгахаар байна. Энэ талаар нийтийн эмийн сангийн эрхлэгч нь ярилцлагын явцад саналаа өгсөн болно.

**Б.2.2 Нэгдсэн эмнэлэгт клиник эмзүйн албыг байгуулах, мэргэжлийн клиник эм зүйчдийг ажиллуулах шаардлага бий болж байна.**

Нэгдсэн эмнэлэгт эмийн эмчилгээ зохицуулах хорооны даргаар эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, нарийн бичгээр клиник эм судлаач гишүүдээр эм зүйч, нян судлаач эмч, тархвар судлаач эмч, эмийн нягтлан бодогч болон нийт тасгийн эрхлэгч эмч нарын 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр Эрүүл мэндийн сайдын А/414 тоот тушаалын дагуу хорооны үйл ажиллагааг явуулж байна.

Клиник эм зүйч нь эмчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, эмийн хэрэглээг үнэлэх, эмчилгээг зохицуулахад эмчтэй хамтран ажиллах, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эмчилгээг чанд дагаж мөрдөхөд нь дэмжлэг үзүүлэх, тухайн иргэнд

тохирсон эмчилгээ, нийгмийн эрүүл мэндийн болон урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад шаардагдах мэдээллээр хангах зэрэг үүрэгтэй байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дугаар тушаалын хавсралтаар “Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм”-ийг баталжээ. Энэ дүрмийн зорилго нь эмнэлгийн эм зүйн албаны /эмийн сан/ бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох, эм зүйн тусламж үйлчилгээг багаар үзүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмийн эмчилгээний үр дүнг хянах, чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллахад оршиж байгаа юм.

Эм зүйн алба нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмнэл зүйн эм зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулахаар байна. Эм зүйн алба нь мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий менежментийн баг, мэргэжлийн баг, дэмжих багаас бүрдэнэ.

Эм зүйн албаны төлөөлөл нь эмнэлгийн Эмчилгээний зохицуулах хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах ба тусламж үйлчилгээнд чанартай, аюулгүй эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах, эмийг зөв зохистой хэрэглэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахаар байна.

Мөн эм зүйч нь эмчлүүлэгчийн эмчилгээний түүхийг шалгаж эмийг зохистой хэмжээнд хэрэглэж байгаа эсэхийг нягтлахын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд эмчилгээ хийсэн эсэхийг лавлахаар байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эм зүйн алба байгуулагдаагүй боловсон хүчин дутмаг, эмийн сангаас эмийг олгохдоо тасагт хүргэж өгөх боломжгүй байна. Өнөөгийн хэрэгцээ шаардлагыг үнэлж үзэхэд Нэгдсэн эмнэлэгт клиник эмзүйн албыг байгуулах, мэргэжлийн клиник эм зүйчдийг ажиллуулах шаардлага бий болжээ.

### **Б.2.3 Эмийн сангийн мэргэжлийн хүн хүчнийг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулах шаардлагатай байна.**

Эмийн санд тавих шаардлагын 7.1-т “Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байна”, 7.2-т “Эмийн сангийн удирдлага нь мэргэжлийн хүн хүчнийг мэргэшүүлэх болон давтан сургалтын төлөвлөгөө батлан мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”, 7.3-т “Нийтийн үйлчилгээний эмийн сангийн мэргэжлийн хүн хүч нь эмзүйн шинжлэх ухааны, нийгмийн эрүүл мэндийн, ёс зүйн чиглэлээр тасралтгүй сургалтад хамрагдсан байна.”, 7.5-т “Эмнэлгийн эмийн сангийн эм зүйч нь клиник эмзүйн чиглэлээр мэргэшүүлэх, давтан сургалтад хамрагдсан байна” гэж эмийн мэргэжилтний хөгжлийн талаар заасан.

Эмийн мэргэжилтний хөгжлийн талаар: /Хавсралт-6,7,8,9/

- ✓ Нийтийн эмийн сангийн 28 эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдаагүй.
- ✓ Нийтийн үйлчилгээний эмийн сангийн мэргэжлийн хүн хүч нь эмзүйн шинжлэх ухааны, нийгмийн эрүүл мэндийн, ёс зүйн чиглэлээр тасралтгүй сургалтад хамрагдаагүй.
- ✓ Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн эм зүйч нь клиник эм зүйчийн чиглэлээр мэргэшүүлэх давтан сургалтад хамрагдаагүй.

Мөн МХГ-ын био бэлдмэлийн хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалтад хамруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

### **Б.2.4 Иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг сургалт, сурталчилгааны ажлыг зохистой хэмжээнд зохион байгуулжээ.**

*Иргэдэд зохион байгуулсан сургалт:*

2019 онд ЭМГ-ын даргын баталсан удирдамжаар “Эмийн зохистой хэрэглээ” “Антибиотикийн дасал” сэдвүүдээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрх, эмийн сангууд 81 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулжээ.

*Зураг-4*



Зураг-5



Тайлант онд ЭМГ-аас эмийн сангуудтай хамтран “Антибиотикийн зохистой хэрэглээ”, “Эмийн гаж нөлөө”, “Эм уух уу болих уу” сэдвүүдээр 3 удаагийн сургалтыг 2 төрийн байгууллага, ахмадын хорооны ахмад нийт 166 иргэдэд сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтаар эмийн хор нөлөөг танилцуулж, мөн дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод буй нянгийн тэсвэржилтээс сэргийлэх, антибиотикийг зөв зохистой хэрэглэх талаар сургалт сурталчилгааг хийжээ.

**Эмч мэргэжилтнүүдэд зохион байгуулсан сургалт:**

“Нянгийн тэсвэржилтээс сэргийлье”, “Жор хэн сайн бичих вэ” сэдвээр эмч, эмийн мэргэжилтнүүдэд 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, дэлхийн нийтийн тулгамдсан асуудал болоод буй нянгийн тэсвэржилттэй тэмцэж, антибиотикийн даслаас сэргийлэхийг эмч, мэргэжилтнүүдэд уриалсан байна.

ЭМГ-ын даргын баталсан “Нэг агшин ” сэдэвт сургалтын удирдамжийн дагуу “Говь-Алтай эм хангамж” эмийн санд Цагдаагийн хэлтэстэй хамтран мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт хамгаалалт сургалтыг зохион байгуулсан.

Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмч нарт “Эмийн зохистой хэрэглээ” “ЭМД-ын сангаас хөнгөлөлт эдэлдэг эм”-ийн талаар сургалт хийж 42 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

**Эмийн сангуудтай хамтран хийсэн сургалт**

“Монос Говь-Алтай ХХК-тай хамтран “Өглөө клуб”-ын 84 иргэдэд “Эмийн зохистой хэрэглээ сэдвээр сургалт зохион байгуулан сургалтын материал тарааж витаминжуулалт хийжээ. “Бамбайн үндэс”, “Ариун тун” эмийн сантай хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, 62 иргэнийг хамруулан антибиотикийн зохистой хэрэглээний талаар ойлголтыг нь нэмэгдүүлж, 55 гарын авлага тараалаа.

Зураг-6



“Монос трейд ХХК” “КРКА” Монфа ХХК”-ийн эмч төлөөлөгчтэй хамтран, “Даралт бууруулах эм”, “Монос үйлдвэрийн бүтээгдэхүүн” сэдвээр 84 эмч эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйч, эм найруулагч нарт сургалтыг зохион байгуулжээ.

**Мэргэжлийн хяналт:**

Эм био бэлдмэлийн хяналтын чиглэлээр 3.1.2 кодтой “Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах”, 3.2 кодтой “Эм, био бэлдмэлийн үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах”, 3.3 кодтой “Эмийн сангийн үйл ажиллагааг шалгах”, 3.4 кодтой “Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний хадгалалт, түгээлтийг шалгах” хяналтын хуудсаар эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэн, хяналт шалгалт хийж байна.

**Мэргэжлийн хяналт шалгалт**

Хүснэгт-4

№	он	Шалгалт	Гүйцэтгэл
1	2018	21	12
2	2019	14	10
3	2020	17	17
4	2021	19	-

**Ногдуулсан шийтгэвэр**

Хүснэгт-5

/мянган төгрөг/

№	он	Шийтгэлийн тоо	Мөнгөн дүн	Барагдуулалт
1	2018	3	2,000.0	100%
2	2019	10	5,000.0	100%
3	2020	-	-	-
4	2021	1	50.0	100%
<b>НИЙТ</b>		14	7050.0	

Эх сурвалж: МХГ-ын Эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч

МХГ нь 2018 оноос 2020 онд нийт 39 нэгжид эм, био бэлдмэлийн чиглэлээр хяналт шалгалт хийжээ. Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан байгууллагуудад зөрчил, дутагдал илэрснийг арилгуулах албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн, холбогдох хууль, дүрэм, заавар, журмыг сурталчлан таниулж, цаашид хэрэгжүүлэн ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ба зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтанд нийт 7,050.0 мянган төгрөгийн шийтгэвэр тавьж барагдуулжээ.

**Дотоод хяналт:**

Эмийн санд тавих нийтлэг шаардлагын 14.2.9-т “Эмийн санд байгаа эмийн болон эрүүл мэндийн бүтээгдэхүүний чанарт дотоод хяналтыг тавина” гэж заажээ. Гэвч сумдын ЭМТ нь дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

**Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн талаар:**

Аймгийн МХГ болон ЗДТГ-ын дэргэдэх 70481111 санал, гомдол хүлээн авах дугаарт эмийн хөнгөлөлт, үнэ, эмнэлгийн эмийн нөөц, эмч нарын харилцаатай холбоотой гомдол 2020 онд 13, 2021 онд 3 нийт 16 бүртгэгдсэн байна. Иргэдээс ирсэн гомдлын дагуу арга хэмжээ авч хариу хүргүүлжээ.

**ИЛРҮҮЛЭЛТ:**

**Эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах ажлын талаар:**

1. Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-д 2018 оноос 2021 онуудад эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа Тендерт шалгараагүй, иргэн ААНБ-с 1,184,836.2 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. Үүнээс 554,532.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулалгүйгээр, 767,391.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн сан, хувь хүнээс /жижиглэнгийн үнээр/ худалдан авалт хийжээ.
2. Аудитаар Нэгдсэн эмнэлгийн 2020, 2021 оны 11,897 өвчтөний түүхийг түүвэрчилж үзэхэд 1,564 иргэн эрүүл мэндийн даатгал бүрэн төлсөн боловч өөрөөсөө хэрэглэсэн 79,611.3 мянган төгрөгийн эмийн үнийг нэхэмжлээгүй байна. Энэ нь нэг талаар иргэд хууль эрх зүйн мэдлэг дутмаг нөгөө талаас эмнэлэг зайлшгүй байх нөөцийг бүрдүүлж ажиллагаагүйтэй холбоотой.

**Эмийн сангийн барилга байгууламж, өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмж, эм хадгалалт, эмийн санд тавигдах эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтийн талаар:**

**Эм ханган нийлүүлэх байгууллагын хувьд:**

3. Байр нь ачаа буулгах, тээвэрлэхэд хүрэлцэхүйц гадна талбайгүй.
4. Ази фарм ХХК, Мөнхийн тун ХХК хадгалалтын горимд нийцсэн агуулахгүй.
5. Мөнхийн тун ХХК нь эмийн сангийн агаарыг цэвэршүүлэх зорилгоор суурин буюу зөөврийн нян устгах гэрлийг ажиллуулаагүй.

**Нийтийн эмийн сангийн хувьд:**

6. Бугат, Дэлгэр, Төгрөг, Цээл, Чандмань, Шарга, Халиун сумын хувийн эмийн сан нь сумын ЭМТ-ийн байранд байрлаж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Чандмань сумаас бусад нь түрээсийн төлбөр төлдөггүй байна.
7. Дарив, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Цээл, Чандмань, Эрдэнэ сум, Баянтоорой тосгоны нийтийн эмийн сангийн үйлчлүүлэгчдэд зориулсан хаалга нь бараа хүлээн авах хаалганаас ангид байхгүй.
8. Цалгих буянт ХХК Тунамал эмийн сан, Бугат, Төгрөг, Цээл, Чандмань Шарга, Эрдэнэ сум, Гуулин тосгоны нийтийн эмийн сан нь эм, эмнэлгийн хэрэгсэл, туслах материал, түүхий эдийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах нөхцөл бүрдүүлсэн нөөцийн өрөөгүй.
9. Ихэнх нийтийн эмийн санд ажилчдын амралтын өрөө, эрхлэгчийн өрөө, ариун цэврийн өрөө байхгүй.
10. Бугат, Жаргалан, Чандмань сумын нийтийн эмийн сан нь эм хадгалах хөргөгч, хөргүүргүй.
11. Шарга сумын нийтийн эмийн санд бар кодын машин эвдэрсэн, Баянтоорой тосгоны эмийн сан нь сүлжээ байхгүйн улмаас бар кодын машин ашигладаггүй байна.
12. Бугат, Дэлгэр, Жаргалан сумын нийтийн эмийн санд нян устгах гэрэл байхгүй
13. Аминдэм-Алтай ХХК, Хишиг Арвин дэлгэрэх, Түмэн туяа ХХК, Ариунтан Алтай ХХК, Номгон гэгээн фарм ХХК нь нөөцийн өрөөнд термометр, чийг хэмжигчийг эгзэгтэй цэгт байрлуулаагүй, заалтыг өдөр тутам хянаж, тэмдэглэл хөтлөөгүй.

**Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн хувьд:**

14. Эмийн нөөцийн өрөө хүрэлцээ муутай. Диализын эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалалтын горим зөрчиж ус нэрэх өрөөнд байрлуулсан.
15. Нөөцийн өрөө нь эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах шаардлагыг хангасан хүрэлцэхүйц хэмжээний зориулалтын тавиур, лангуу байхгүй.

16. Нөөцийн өрөөнд термометр, чийг хэмжигчийг эгзэгтэй цэгт байрлуулж, заалтыг өдөр тутам хянаж, тэмдэглэл бүрэн хөтлөөгүй.
17. Агаар ариутгах дэлгэц бүхий нян устгах гэрлийг шалнаас дээш 2 метрийн зайд тусгай сууринд бэхэлж суурилуулаагүй. Нян устгах гэрлийг ажиллуулсан бүртгэл хөтлөөгүй.

**Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн хувьд:**

18. Дарив, Тайшир, Тонхил, Цогт, Шарга, Цээл сумын ЭМТ-ийн эмийн сангийн өрөө нь зориулалтын бус.
19. Эмийн сангийн өрөө тасалгаа шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал эмийн нөөцийн өрөө, ажилчдын амралтын өрөө, ариун цэврийн өрөө, эрхлэгчийн өрөөгүй байна.
20. Эмийн сангийн тавилга, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн шаардлагын хувьд эм хадгалах хөргөгч, компьютер, нян устгах гэрэл, термометр, чийг хэмжигч, зориулалтын тавиургүй.
21. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн орлого, зарлагын бүртгэлийг бүрэн бүртгээгүй.
22. Эмнэлгийн эмийн санч эмийн нэр төрлийн тайлан, үлдэгдлийн мэдээг гаргаагүй, ариутгасан эмийн бүртгэл байхгүй, тасарсан эмийн бүртгэл, зохистой эмийн мэдээлэл сурталчилгаа явуулсан бүртгэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны бүртгэл байхгүй байна.

**Улсын бүртгэлд бүртгэсэн, чанартай, аюулгүй эмийн хэрэглээний талаар:**

23. Эмийн санд хяналт хийхэд 6,631.3 мянган төгрөгийн үнэтэй 129 нэр төрлийн 6,737 ширхэг эмийн хугацаа дууссан, 977 мянган төгрөгийн үнэтэй 19 нэр төрлийн 6,312 ширхэг эмийн хугацаа дуусах дөхсөн, 622.0 мянган төгрөгийн үнэтэй 30 нэр төрлийн 283 ширхэг эм, тарианы хадгалалтын горим алдагдан эмчилгээнд хэрэглэх боломжгүй болсон.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийн ашиглалтын талаар:**

24. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлсэн боловч эрүүл мэндийн байгууллагуудын ашиглалт хангалтгүй, хүн амын эмчилгээнд хэрэглэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэсэн эсэхийг хянадаггүй.

**Эмийн санхүүжилт, үр ашгийн талаар:**

25. ЭМД-ийн сангийн цахим системд өвчтөний мэдээллийг зөрүүтэй шивсэн, өвчтөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй, эмнэлэгт хэвтэх хугацаандаа оношилгоо, амбулаторийн үзлэгт хамрагдсан зэрэг шалтгаанаар 2018 оноос 2020 онуудад нийт 369,779.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авах боломжийг алдсан.
26. Бугат, Дарив, Тайшир, Чандмань сум, Баянтоорой тосгоны ЭМТ-ийн магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан.
27. Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон ЭМД-ын сангаас санхүүжүүлээгүй.

**ЭМД-ийн сангийн санхүүжилтийн хувьд:**

28. Нэгдсэн эмнэлэг нь 36 өвчтөний, Уламжлалт анагаах ухааны төв нь 67 өвчтөний мэдээллийг ЭМД-ийн сангийн цахим сайтад огт шивээгүйгээс 27,846.6 мянган төгрөгийг санхүүжилт авах боломжийг алдсан.
29. ЭМД-ын сангаас 2020 онд олгосон эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тулган үзэхэд Шарга сумд 5, Тайшир сумд 7 өвчтөний түүхийн баримтын бүрдэл дутуу байхад 516.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.
30. Нэгдсэн эмнэлэг нь ЭМД-ын сангаас өвчтөний оношийг зөрүүтэй нэхэмжилсний улмаас 1,839.9 мянган төгрөгөөр санхүүжилтийг илүү, дутуу авсан.

**Эмийн санхүүжилтийн үр ашгийн хувьд:**

31. Нэгдсэн эмнэлэг 17 иргэний эмчилгээний явцад өөрөөсөө хэрэглэн нэхэмжилсэн 7,442.0 мянган төгрөгийн эмийн үнийг буцааж олгоогүй.
32. Нэгдсэн эмнэлгийн 1 өвчтөний эмчилгээний картад өөрөөсөө авсан эмийн бүртгэлгүй байхад 220.0 мянган төгрөгийн эмийн үнийг олгосон.

33. Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслээс 10 нэр төрлийн эмийн зарцуулалтыг өвчтөний түүхийн хэрэглэсэн эмийн жагсаалттай тулгахад 3,285.0 мянган төгрөгийн үнэ бүхий 93 ширхэг эмийн зөрүү гарлаа.
34. Ковидын төлбөртэй оношлуурын үнэ болох 207.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй.
35. Нэгдсэн эмнэлэг нь 2019, 2020, 2021 онд 2 өвчтөнд 4,000 ширхэг 50,000.0 мянган төгрөгийн хэвлийн диализын уусмалыг, 3,973 ширхэг 2,979.7 мянган төгрөгийн хэвлийн диализын уусмалын бөглөөг анхан шатны баримтгүй, эмчийн зөвшөөрлийн бичиггүйгээр гэрээр олгожээ.
36. Нэгдсэн эмнэлэг, “Жаргалан-Алтай”, “Марал-Алтай”, “Энх-Алтай” өрхийн ЭМТ, Дэлгэр, Шарга, Төгрөг, Бугат сум, Гуулин тосгоны ЭМТ-ийн 125 өвчтөний түүхэнд шинжилгээний бичиг байхгүй, Нэгдсэн эмнэлэгт 4 өвчтөний түүхэнд хэвтэх зөвшөөрлийн бичиг байхгүй байхад эмчилгээг хийсэн байна.

**Эмийн тооллогын хувьд:**

37. Эмийн биет тооллого хийхэд байвал зохих үлдэгдлээс 36,720.5 мянган төгрөгийн 43,149 ширхэг эм илүүдэж, 32,791.2 мянган төгрөгийн 38,745 ширхэг эм дутагдлаа. Энэ нь нэг талаас эмийн санч эмийн нэр төрлийн тайлан гаргадаггүй, нягтлан бодох бүртгэлд байгаа эмийн үлдэгдэл эмийн санд байгаа үлдэгдлээс нэр, төрөл, тоо хэмжээ, үнийн хувьд зөрүүтэй, нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлээр хяналт тавьж алдааг засварладаггүйтэй холбоотой.
38. Нэгдсэн эмнэлгийн диализын тасагт хэрэглэсэн эмийн орлого зарлагын тайлан зөрүүтэй, анхан шатны баримтаар нотлогдохгүй, эмийн сангийн байвал зохих үлдэгдлээс 8,307.5 мянган төгрөгийн үнэтэй 841 ширхэг эмийн зөрүүтэй байна. Тус тасагт байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл нь эмнэлгийн эмийн санд байршуулаагүй, бүртгэл тооцооны хяналтгүй зарцуулагдаж байна.
39. Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн нөөцөд зайлшгүй байх эм, тарианд тооллого хийхэд байвал зохих үлдэгдлээс 136 нэр төрлийн 374 ширхэг эм тариа дутагдаж, 112 нэр төрлийн 347 ширхэг эм тариа илүүдсэн.

**Эмийн сангийн удирдлага, хүн хүчний хангамж, мэргэжилтнүүдийн талаар:**

40. Дарив, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ сум, Баянтоорой тосгоны ЭМТ-ийн эмийн сангийн эрхлэгчийн үүргийг эм найруулагч мэргэжилгүй ажилтан гүйцэтгэж байна.
41. Дэлгэр, Төгрөг сум, Гуулин тосгоны ЭМТ-ийн эм найруулагч нь үндсэн ажиллаж буй эмийн сангаас гадна сумын хувийн эмийн сангийн эрхлэгчээр давхар ажиллаж байна. Мөн Баян-Уул сумын эмийн санч нь Баян гурван жаргалант БГБХН-ийн Мөнгөн дэгд эмийн сангийн эрхлэгчтэй харилцан хамаарал бүхий байна.
42. Ази фарм ХХК, Эм хангамж ХХК, Хишиг Арвин дэлгэрэх ХХК, Сант арвин ХХК Ээлт эмийн сан, Номгон гэгээн фарм ХХК-ийн эмийн сангийн эрхлэгч нь мэргэжлээрээ 3-аас доош жил ажилласан байхад эмийн сангийн үйл ажиллагааг гардан удирдаж, эрхлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.
43. Нэгдсэн эмнэлэг нь 231 ортой бөгөөд үүнд 5-6 клиник эм зүйч ажиллахаар байна. Гэвч мэргэжлийн клиник эм зүйч байхгүй, 1 эм судлаач ажиллуулж байна.
44. Нэгдсэн эмнэлэг нь эм зүйн алба байгуулаагүй, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

**Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн талаар:**

45. Эмийн жор бичилт хангалтгүй, эм олголтод тавих хяналт үр дүнгүй байна.
46. Нийтийн эмийн сангийн 28 эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдаагүй.
47. Нийтийн үйлчилгээний эмийн сангийн мэргэжлийн хүн хүч нь эмзүйн шинжлэх ухааны, нийгмийн эрүүл мэндийн, ёс зүйн чиглэлээр тасралтгүй сургалтад хамрагдаагүй.
48. Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн эм зүйч нь клиник эм зүйчийн чиглэлээр мэргэшүүлэх давтан сургалтад хамрагдаагүй.
49. Сумдын ЭМТ нь дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

## Ерөнхий Дүгнэлт

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ЧАНАРТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР НӨЛӨӨГ ТООЦОЖ АЖИЛЛАХААР БАЙНА.**

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

## Зөвлөмж

### Аймгийн Эрүүл мэндийн газарт:

1. Эмийн мэргэжилтнийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах

### Мэргэжлийн хяналтын газарт:

2. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн стандартын шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хангуулах
3. Эмийн био бэлдмэлийн хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалтад хамруулах

### Нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ-д:

4. Зайлшгүй байх эмийн нөөцийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
5. Эмийн санд тавих шаардлагыг мөрдөж ажиллах
6. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг ашиглаж хэвших
7. ЭМД-ийн сангийн цахим системийн шивэлтэд программаар хяналт тавих
8. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд оруулах
9. Нэгдсэн эмнэлэгт клиник эмзүйн албыг байгуулж, мэргэжлийн боловсон хүчин ажиллуулах.

## Албан шаардлага

### Аймгийн Эрүүл мэндийн газарт:

1. Эмийн санд мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулж, хувийн эмийн сангийн эрхлэгчээр эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааг давхар эрхлүүлэхгүй байж зөрчлийг арилгах
2. Эмийн жор бичилтийн стандартын шаардлагыг хангуулах, эмийн сангаар эмчийн жоргүйгээр эм олгодог явдлыг таслан зогсоох

### Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, өрхийн ЭМТ, сумын ЭМТ-д:

1. “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандартын дагуу зөвхөн гэрээт эм ханган нийлүүлэх байгууллагаас чанартай баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах.
2. Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөх.
3. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн, зарцуулж бүртгэлийн удирдлагыг сайжруулах
4. Эмийн хадгалалтын нөхцөл, орчны шаардлагыг хангуулан ажиллаж, хугацаа дууссан болон дуусах дөхсөн эмийн талаар арга хэмжээ авах
5. Орон нутгийн өмчийг хувийн хэвшилд зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй ашиглуулж байгааг хуулийн хүрээнд шийдвэрлэх
6. ЭМД-ийн сангийн цахим системд өвчтөний мэдээллийг үнэн зөв оруулж, хяналт тавих
7. Эм, эмнэлгийн хэрэгслийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх
8. Эм, эмнэлгийн хэрэгсэлд бүртгэлээр болон дотоод хяналтыг хийж, тооллогоор илэрсэн зөрчлийг арилгуулах
9. Эмийн санд мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулж, хувийн эмийн сангийн эрхлэгчээр эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааг давхар эрхлүүлэхгүй байж зөрчлийг арилгах

10. Эмийн жор бичилтийн стандартын шаардлагыг хангуулан, эмийн сангаар эмчийн жоргүйгээр эм олгодог явдлыг таслан зогсоох
11. Дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах

## Төлбөрийн акт

### Нэгдсэн эмнэлэгт:

1. Иргэдийн нэхэмжилсэн 7442.0 мянган төгрөгийн эмийн үнийг олгох
2. Ковидын оношлуурын 207.4 мянган төгрөгийг төвлөрүүлэх

## Уламжлах

### ҮАГ-ын аудитын гуравдугаар газарт уламжлан нэгдсэн тайланд тусгаж харьяалах ТЕЗ-д зөвлөмж өгөх:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн зардлын төсвийг баталж өгөх асуудлыг шийдвэрлэх
2. Эмчийн жор бичилтийг цахимжуулах боломжийг судлан шийдвэрлэх
3. Улсын бүртгэлтэй эмийг шалгах бар код, сери дугаар уншдаг шалгах хуудас, программ, төхөөрөмжийг бий болгох асуудлыг холбогдох албан тушаалтанд уламжлах

Холбогдох байгууллагын санал:



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

82091 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг  
Утас/Факс: 70-48-40-66

2021. 11. 11 № 781

танай 2021. 11. 10 -ны № 514 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, шийдвэрийн төсөлтэй танилцлаа.

Цаашид зөрчил арилгуулах тухайз шийдвэрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВАЖАРГАЛ

